



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 147

Булагтай

Сумын 2020 оны газар зохион байгуулалтын
төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з”, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 28 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөөний “Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх” нийт 7,5 га газрын тус бүрийн байршил хэмжээг **1-р** хавсралтаар, “Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх” нийт 514 м² га газрын тус бүрийн байршил хэмжээг **2-р** хавсралтаар, “Гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж, байгууллагад төмс, хүнсний ногоо, таримал мод, ургамал тариалах зориулалтаар эзэмшүүлэх” нийт 16 га газрын тус бүрийн байршил хэмжээг **3-р** хавсралтаар, “Аж ахуйн нэгж байгууллагад хөдөө аж ахуйн барилга байгууламжийн зориулалтаар эзэмшүүлэх” нийт 2500 м² газрын тус бүрийн байршил хэмжээг **4-р** хавсралтаар, “Иргэнд өвөлжөөний зориулалтаар эзэмшүүлэх” нийт 51,48 га газрын хэмжээ байршлыг **5-р** хавсралтаар, “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар шинээр эзэмшүүлэх” нийт 3 га газрын хэмжээ байршлыг **6-р** хавсралтаар, “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шашин, бөө мөргөлийн зориулалтаар шинээр эзэмшүүлэх” 0,5 га газрын хэмжээ байршлыг **7-р** хавсралтаар, “Аж ахуйн нэгж, байгууллагад барилга байгууламжийн зориулалтаар эзэмшүүлэх” нийт 1,5 га газрын тус бүрийн байршил хэмжээг **8-р** хавсралтаар, “Аж ахуйн нэгж, байгууллагад уул уурхайн зориулалтаар эзэмшүүлэх” нийт 551,58 га газрын тус бүрийн байршил хэмжээг **9-р** хавсралтаар, “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад аялал жуулчлалын газрын зориулалтаар эзэмшүүлэх” нийт 3 га газрын тус бүрийн байршил хэмжээг **10-р** хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумын Засаг дарга /Д.Пүрэвдорж/-д ДААЛГАХ нь :

2.1. Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсаны дагуу газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зориулалтын дагуу өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг журам зааврын дагуу шуурхай зохион байгуулж шийдвэрлэх

2.2. Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа, гэрээний биелэлтэд хяналт тавьж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажиллах

2.3. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан дуудлага худалдаагаар олгогдох газруудыг эхний гурван улиралд багтаан зохион байгуулж шийдвэрлэх

3. Газар эзэмших, ашиглах, өмчлүүлэх ажил, иргэн, ААН, байгууллагын газрын эзэмшилт, ашиглалтын байдалд байнга хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгуулах талаар арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны улсын байцаагч /Г.Энхтүвшин/-д даалгасугай.

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАТ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН 2020 ОНЫ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ**

Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 147 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.

Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар
шинээр өмчлүүлэх газрын хэмжээ, байршил

Д/д	Багийн нэр	Газрын байршил	Иргэний тоо	Газрын хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хариуцах эзэн
						1	2	3	4	
1	Тарвагатай 1-р баг Баянцагаан 2-р баг	Бэлчир Хайрханы энгэр	30	7.5	Гэр бүлийн хэрэгцээний					Засаг дарга, Газрын даамал
Нийт			30	7.5						

....ооо.....

Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 147 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх
газрын хэмжээ, байршил

Д/д	Багийн нэр	Газрын байршил	Иргэн, ААН-ийн тоо	Газрын хэмжээ /м2/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хариуцах эзэн
						1	2	3	4	
1	Тарвагатай 1-р баг	Сумын төв /Аз кафены урд/	1	450	Цайны газрын өргөтгөл					Засаг дарга, Газрын даамал
2	Баянцагаан 2-р баг	Сумын төв /сумын жимс ногоо даршлах цехийн хажуу талд/	1	64	Талхан цех					Засаг дарга, Газрын даамал
Нийт			2	514						

....ооо.....

Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 117 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

Гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж, байгууллагад төмс, хүнсний ногоо, таримал мод, ургамал тариалах зориулалтаар эзэмшүүлэх

Д/д	Багийн нэр дугаар	Газрын байршил	Өрхийн тоо	Газрын хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хугацаа хариуцах эзэн
						1	2	3	4	
1	Тарвагатай 1-р баг	Төмөртэй голын урд талд, Хуучин хүдэр	6	11	Төмс х.ногоо					Засаг дарга, Газрын даамал
2	Тарвагатай 1-р баг	Шоргоолз	1	2	Мод үржүүлэг					Засаг дарга, Газрын даамал
3	Тарвагатай 1-р баг	Хуучин тарианы 1-р бригадын орчим	1	3	Ногоон тэжээл тариалах					Засаг дарга, Газрын даамал
	Дүн		8	16						

Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 117 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хөдөө аж ахуйн барилга байгууламжийн зориулалтаар эзэмшүүлэх газрын хэмжээ байршил

Д/д	Багийн нэр	Газрын байршил	Иргэн, ААН-ийн тоо	газрын хэмжээ /м2/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хариуцах эзэн
						1	2	3	4	
1	Баянцагаан 2-р баг	Сумын төв /Ургац Хүдэр ХХК-ий үтрэмийн хашааны урд талд/	1	2500	Үтрэмийн хашааны өргөтгөл					Засаг дарга, Газрын даамал
	Дүн		1	2500						

.....ооо.....

Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 117 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт.

Иргэнд өвөлжөөний зориулалтаар эзэмшүүлэх газрын хэмжээ байршил

д/д	Багийн нэр	Газрын байршил	Иргэний тоо	Газрын хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хариуцах эзэн
						1	2	3	4	
1	Тарвагатай 1-р баг	Дуганы хонхор, Салхитын хошуу, Ганц модны энгэр, Нарийн хөндий, Наймын гүүр, Дөрөө хавирдаг, Хүдэрийн адаг, Жаргалант, Сэвсуул, Бумбат	52	40,56	өвөлжөө					Засаг дарга, Газрын даамал
2	Баянцагаан 2-р баг	Хуучин Хүдэр, Төмөртэй, Бэлчир, Хэрц	14	10,92	өвөлжөө					Засаг дарга, Газрын даамал
Нийт			66	51,48						


....ооо.....

Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 117 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар шинээр эзэмшүүлэх газрын хэмжээ байршил

д/д	Багийн нэр	Газрын байршил	Иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Газрын хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хариуцах эзэн
						1	2	3	4	
	Тарвагатай 1-р баг	Хурниад Хүдэр ХХК-ий бригадын зүүн талд	1	3	Сүүний ферм					Засаг дарга, Газрын даамал
Нийт			1	3						

....ооо.....




Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 77 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шашин бөө мөргөлийн эзэмшүүлэх газрын хэмжээ байршил

д/д	Багийн нэр	Газрын байршил	Иргэн, ААН-ийн тоо	Газрын хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хариуцах эзэн
						1	2	3	4	
1	Тарвагатай 1-р баг	Бумбатын эх	1	0,5	Шашин бөө мөргөлийн					Засаг дарга, Газрын даамал
Нийт				0,5						

....00о....



Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 77 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

Аж ахуйн нэгж, байгууллагад барилга байгууламжийн зориулалтаар эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил

д/д	Багийн нэр	Газрын байршил	Иргэн, ААН-ийн тоо	газрын хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хариуцах эзэн
						1	2	3	4	
1	Баянцагаан 2-р баг	Шоргоолж,	1	1	Байгаль хамгаалагчийн хяналтын байр					Засаг дарга, Газрын даамал
2	Баянцагаан 2-р баг	Хүдэрийн Адаг /Шугуйтын гол, Хүдэрийн голын уулзвар/	1	0.5	Байгаль хамгаалагчийн хяналтын байр					Засаг дарга, Газрын даамал
Нийт			2	1.5						

....00о....

Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 147 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

Аж ахуйн нэгж, байгууллагад уул уурхайн зориулалтаар эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил

Д/д	Багийн нэр	Газрын байршил	Иргэн, ААН-ийн тоо	газрын хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хариуцах эзэн
						1	2	3	4	
1	Тарвагатай 1-р баг	Төмөртэй	1	1	Тэсрэх бодис хадгалах агуулах					Засаг дарга, Газрын даамал
2	Тарвагатай 1-р баг	Бүдүүний гол	1	550.58	Уул уурхай					Засаг дарга, Газрын даамал
Нийт			2	551.58						

....о0о....

Сумын ИТХ-ын 2019 оны 12-р сарын 18-ны өдрийн 147 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт.

Иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагад аялал жуулчлалын газрын зориулалтаар эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил

Д/д	Багийн нэр	Газрын байршил	Иргэн, ААН-ийн тоо	газрын хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сар/				Хариуцах эзэн
						1	2	3	4	
1	Тарвагатай 1-р баг	Төмөртэй /малчин Сүрэнжавын өвөлжөөний урд/	1	1	аялал жуулчлал					Засаг дарга, Газрын даамал
2	Тарвагатай 1-р баг	Төмөртэй /Сэлэмхайрхан уулын хойд тал, хуучин трансформаторын ойролцоо/	1	1	аялал жуулчлал					Засаг дарга, Газрын даамал
3	Тарвагатай 1-р баг	Төмөртэй /16-ын даваа өгсөөд/	1	1	аялал жуулчлал					Засаг дарга, Газрын даамал
Нийт			3	3						

....о0о....